Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга И.Исатай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 16-аас 2022 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэв.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сагсай сум нь “Хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал, санаачилгад тулгуурлан хэрэгжүүлсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж аймгийн “Загвар сум” болох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сумын нийгэм, эдийн засгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хүрэх түвшнийг тодорхойлж иргэн бүр эрүүл, боловсролтой, орлоготой, амьжиргааны чадавхтай болно.
- Байгалийн баялаг, түүхий эдэд тулгуурласан хөгжлийг бий болгоно.
- Ард иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Их бүтээн байгууллалт өрнүүлнэ.
- Төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг өндөржүүлж, төрийн үйлчилгээний нээлттэй, шуурхай, шударга, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг эрхэмлэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд

нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Сагсай сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд шалгалт хийгээгүй байна.

Тус сумын дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,231.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 84.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 67.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 74.6 сая, эцсийн үлдэгдэл 377.9 сая төгрөг болж, 303.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	74.6	377.9	303.3	406.5
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>74.6</b>	<b>377.9</b>	<b>303.3</b>	<b>406.5</b>

Эх сурвалж: Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 375.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 268.0 сая төгрөг болж, 8.9 сая төгрөгөөр буурсан байна. *Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	8.4	5.1	-3.3
Төлбөртэй үйлчилгээний авлага		16.9	16.9
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	2.4	8.1	5.7
Бусад авлага	2.3	32.9	30.6
Зээлийн авлага	263.8	205.0	-58.8
<b>Дүн</b>	<b>276.9</b>	<b>268.0</b>	<b>-8.9</b>

Эх сурвалж Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 1-ээс 3 жилийн насжилттай авлага ба энэ нь тухай бүр өөрчлөгдөж байна.

Нийт авлагын 213.1 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 15.0 сая төгрөг нь Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн, 17.9 сая төгрөг нь 2 дугаар цэцэрлэгийн, 18.2 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 2.9 сая төгрөг нь Эргэлтийн эмийн сангийн авлага байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны үлдэгдэл 326.9 сая төгрөг болж, 60.2 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	11.3	25.4	14.1
Бэлэн бүтээгдэхүүн		22.7	22.7
Хангамжийн материал	231.9	255.2	23.4
Мал амьтад	23.5	23.5	0.0
Нөөцийн бараа			0.0
<b>Дүн</b>	<b>266.7</b>	<b>326.9</b>	<b>60.2</b>

Эх сурвалж: Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Бараа материалын үлдэгдэл өссөн нь төсөвт байгууллагууд тайлант онд 34.6 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, зарим төсөвт байгууллага бараа материалыг их хэмжээгээр худалдан авалт хийж нөөц үүсгэснээс шалтгаалжээ. Тухайлбал: Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 64.1 сая төгрөгийн хүнсний бараа материалын үлдэгдэлтэй байгаа нь сумын нийт дүнгийн 64.2 хувийг эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Засаг даргын тамгын газар малжуулах төслийн хүрээнд сумын иргэдэд олгосон бодитоор байхгүй 23.5 сая төгрөгийн малыг бараа материалын дансанд бүртгэж ирсэн.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нярвын бараа материалын тайланг сар бүр авч, орлого, зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулж тооцоо хийгээгүй, нярвын хүнсний материалын орлогын дүн, бараа материалын тодруулга тайлангийн орлогын дүнгээс 18.9 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын тодруулга тайланд үдийн хоолны хүнсний материалын орлогыг 1.8 сая төгрөгөөр илүү, дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материалын орлогыг мөн хэмжээгээр дутуу тайлагнасан.

Эрүүл мэндийн төв нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлийг тулган баталгаажуулах боломжгүй. Санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл нярвын материалын тайлангаарх эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүн, тооллогын дүнгээс 42.1 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй.

Эмийн 15.6 сая төгрөгийн үлдэгдэлийн тооллогын баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасанш нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй байна.

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9,274.6 сая төгрөг болж 2,654.3 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,519.8	9,173.9	2,654.1

Биет бус хөрөнгө	100.5	100.7	0.2
<b>Дүн</b>	<b>6,620.3</b>	<b>9,274.6</b>	<b>2,654.3</b>

Эх сурвалж: Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 68.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 2,849.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсөвт байгууллагууд тайлант онд үндсэн хөрөнгөнд 263.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Засаг даргын тамгын газар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 27.6 сая төгрөгийн өртөг бүхий зуслан, хаваржаа, намаржааны зам засварын 6 ажлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн.

Эрүүл мэндийн төв жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

#### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 15.2 сая төгрөг болж, 60.2 сая төгрөгөөр буурсан байна. Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон өглөг	12.3	0.1	-12.1	0.6%
Бараа үйлчилгээний зардлын өглөг	45.5	14.1	-31.4	92.7%
Байгууллагад төлөх өглөг	17.6	1.0	-16.6	6.6%
Хувь хүмүүст төлөх өглөг	16.2			
<b>Нийт дүн</b>	<b>75.4</b>	<b>15.2</b>	<b>-60.2</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 15.2 сая төгрөгийн 92.7 хувийг буюу 14.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлын, 6.6 хувийг буюу 1.0 сая төгрөгийг байгууллагад төлөх, 0.6 хувийг буюу 0.1 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой өглөг тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагуудаас Засаг даргын тамгын газар 4.5 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2.9 сая, Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 3.3 сая, 3 дугаар цэцэрлэг 3.1 сая, Эрүүл мэндийн төв 0.8 сая төгрөгийн өглөгтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг он дамжсан өр, төлбөрийг бүрэн барагдуулаагүй, Хүүхдтийн 3 дугаар цэцэрлэг оны эцэст 2.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн боловч 3.1 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 10,232.4 сая төгрөг болж, 3,069.3 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,163.0	10,232.4	3,069.4	100%
Хуримтлагдсан үр дүн	533.5	3,602.9	3,069.3	35.1%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,333.9	3,333.9	0.0	32.5
<b>Дүн</b>	<b>7,238.4</b>	<b>10,247.5</b>	<b>3,009.1</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 10,232.4 сая төгрөг болж 3,069.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 3,602.9 сая төгрөг болж 3,069.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 3,069.3 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 3,333.9 сая төгрөг байна. Бодлогын өөрчлөлт алдааны залруулга гараагүй байна.

### 3.5.10 Орлогын данс

Сагсай сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 285.9 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 3,638.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 632.6 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 159.5 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 51.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 161.6 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 120.9 сая төгрөгийн орлого, үнэ төлбөргүйгээр 2,849.5 сая төгрөгийн хөрөнгө, 34.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч нийтдээ 7,933.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал зардал 4,667.4 сая, хөрөнгийн зардал 166.7 сая төгрөг байна.

Урсгал зардлын 3,175.8 сая төгрөг буюу 68 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшлын, 420.7 сая төгрөг буюу 9.0 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 259.7 сая төгрөг буюу 5.6 хувийг байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, 86.2 сая төгрөг буюу 1.9 хувийг хангамж, бараа материалын зардал, 402.9 сая төгрөг буюу 8.6 хувийг нормативт зардал, 116.5 сая төгрөг буюу 2.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 137.4 сая төгрөг буюу 2.9 хувийг урсгал шилжүүлэг, 1.5 хувийг бусад зардал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

*Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн ЗДТГ 4.9 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2.6 сая, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 0.9 сая, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 2.7 сая, 2 дугаар цэцэрлэг 3.0 сая, 3 дугаар цэцэрлэг 3.1 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.*

*Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нормативт зардлын гүйцэтгэлд хүүхэд-өдрөөр хяналт тавьж, хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлж ажиллаагүйгээс оны эцэст үдийн хоолны зардлаар 22.7 сая төгрөгийн хүнсний зүйл нөөцөлж Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн байна.*

*Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчид 0.3 сая төгрөгийн томилолтын мөнгийг үндэслэх, нотлох баримтгүй олгосон.*

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Сагсай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 4,650.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4,475.3 сая төгрөгийг урсгал зардалд, 175.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна.

Нийт зардлын 3,638.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 740.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 159.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 40.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 55.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 15.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Сагсай сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 4,678.0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 3,621.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 740.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 34.1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 159.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 122.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нийт санхүүжилтээс 16.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба ЭМД-ын сангаас 6.2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 62.9 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,550.3 сая төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Аймгийн ИТХ-ын 2020 оны "Орон нутгийн төсөв батлах тухай" 16 дугаар тогтоолоор Сагсай сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 67.6 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны "2021 оны төсөвт тодотгол хийх тухай" 2021 оны 41 дүгээр тодотголоор 67.6 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сагсай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн төсөвт тодотгол хийх тухай 12 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 67.6 сая төгрөгөөр хэвээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 285.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 218.3 сая төгрөгөөр буюу 322.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт №7 Сагсай сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл*

*/сая төгрөг/*

1	Үзүүлэлт	Төлөвлөгө ө	Гүйцэтгэл	Зөрүү	
				дүнгээ р	хувиа р
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>67.6</b>	<b>285.9</b>	<b>218.3</b>	<b>422.7%</b>
	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>67.6</b>	<b>285.9</b>	<b>218.3</b>	<b>422.7%</b>
<b>1</b>	<b>I, ТАТВАРЫН ОРЛОГО</b>	65.8	274.0	208.2	416.2%
<b>2</b>	<b>II.Татварын бус орлого</b>	1.8	11.9	10.1	658.6%

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 218.3 сая төгрөгөөр давж биелэхэд малын тоо, толгойн албан татвараас 10.3 сая, дуудлага худалдааны төлбөр, хураамжаас 19.9 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 191.1 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөгөө давж биелэхэд голлох нөлөөг үзүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хүн амын орлогын албан татвар 8.3 сая төгрөгөөр тасарч, хөрөнгийн албан татвар 8.4 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж 17.7 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 190.3 сая төгрөгөөр, татварын бус орлого 10.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 10.4 сая, бууны албан татвар 1.8 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.4 сая, газрын төлбөр 1.1 сая, түгээмэл тархацтай ашигт малталын нөөц ашигласны төлбөр хураамж 0.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Татварын бус орлогоос хүү, торгуулийн орлого 10.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

- Малын тоо, толгойн албан татварын тухай хууль шинээр батлагдсантай холбоотой сумын ИТХ-ын 2021 оны 17 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд малд ногдуулах албан татвараас 10.3 сая төгрөг оруулсан байна.

-Дуудлагаар худалдсан газрын төлбөр өмнө нь аймгийн төсөвт ордог байсан нь өөрчлөгдөж сум орон нутагт ордог болсонтой холбоотой 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орж дуудлагаар худалдагдсан газрын орлогоос 19.9 сая төгрөг сумын төсөвт орсон байна.

-БОАЖЯ-аас соёлын зориулалтаар шонхор шувуу барих зөвшөөрөл гарсантай холбоотой, тусгай зөвшөөрөлтэй компаниудтай гэрээ хийж 7 шонхор шувууг байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагч нарын хяналтын дор акт үйлдэж 191.1 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 41.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 285.9 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 219.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

*Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	58.20	58.20	-
2	Сумын ЗДТГ	360.70	360.70	-
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2,139.40	2,139.40	-
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	277.40	277.40	-
5	1 дүгээр цэцэрлэг	439.90	439.90	-
6	2 дугаар цэцэрлэг	258.90	244.20	(14.70)
7	3 дугаар цэцэрлэг	135.00	132.80	(2.20)
8	Соёлын төв	84.90	84.90	-
9	Эрүүл мэндийн төв	664.90	657.80	(7.10)
10	ОНХСан	175.30	98.20	(77.10)
11	СХС	55.00	55.00	-
12	Байгаль хамгаалах сан	1.00	1.00	-
	<b>Нийт дүн</b>	<b>4,650.60</b>	<b>4,549.50</b>	<b>(101.10)</b>

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 116.8 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 4.2 сая төгрөгийн нийт 120.9 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 37.7 сая, хангамж, бараа материалын зардалд 11.6 сая, нормативт үардалд 13.1 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 1.2 сая, томилолт, зочны зардалд 0.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 12.2 сая, урсгал шилжүүлэгт 44.8 сая төгрөгийг зарцуулж төсөвт 0.007 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Сагсай сумын Засаг дарга нь 2021 онд нийт 6,087.5 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6,087.5 сая 67 мэдээллийг хугацаанд ил тод байршуулж, 12 мэдээллийг хоцроож байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус Сагсай сумын ТТЗ-ийн багцад хамаарах 14 байгууллага, нэгжийг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Сумын төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын дүнгээр Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт албан шаардлага, ЗДТГ, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгүүдэд зөвлөмж өгсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ шилэн дансанд 14.0 сая төгрөгийн өглөг үүссэн мэдээллийг оруулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль шилэн дансанд 29.1 сая төгрөгийн өглөг үүссэн мэдээллийг оруулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг шилэн дансанд санхүүжилтийн 254.8 сая төгрөгийн 17 мэдээллийг 0 дүнтэйгээр мэдээлсэн, 1 сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 42.2 сая төгрөгийн зарлагын 5 мэдээллийг огт мэдээлээгүй, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, нийт 312.0 сая төгрөгийн зөрчил гаргасан.

Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг шилэн дансанд өр төлбөр үүсгэсэн талаарх 3.1 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сагсай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан заалтууд, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөж шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	0	1	0			100%
<b>Нийт</b>	<b>1</b>		<b>1</b>				<b>100%</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, 5 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулиуд, Хүүхдийн 1, 2, 3 дугаар цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын тайланг түүвэрт хамруулж, Байгаль хамгаалах сан, Эргэлтийн эмийн сан, Төрийн сангуудын тайланг нэгтгэсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

##### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

#### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгээр албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,427.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Хүүхдийн 1, 2, 3 дугаар цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд 218.5 сая төгрөгийн залруулга хийгдэж, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 22.7 сая, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт 0.3 сая төгрөгийн акт тогтоож, ЗДТГ, Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Хүүхдийн 1, 2, 3 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүдэд 931.7 сая төгрөгийн зөрчлийн албан шаардлага, ЗДТГ, Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Хүүхдийн 1, 2, 3 дугаар цэцэрлэгүүдэд 254.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 12 заалт бүхий зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

№ Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>А В</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>11</b>	<b>12</b>	<b>13</b>	<b>14</b>	<b>15</b>	<b>16</b>

1	Сагсай сумын ЗДТГазар	4	70.0					1	4.9	3	65.1
2	Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	6	97.5	1	1.8	1	22.7	1	2.6	3	70.4
3	Сагсай сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	3	2.9	1	1.0		-	1	0.9	1	1.0
4	Сагсай сумын Эрүүл мэндийн төв	4	793.3	3	198.0		-	1	595.4		-
5	Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	4	73.0	1	14.7		-	1	9.3	2	49.1
6	Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	4	11.7	1	2.2		-	1	3.4	2	6.1
7	Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	4	378.9	1	0.9	1	0.3	1	315.2	1	62.5
<b>Дүн</b>		<b>29</b>	<b>1,427.4</b>	<b>8</b>	<b>218.5</b>	<b>2</b>	<b>23.1</b>	<b>7</b>	<b>931.7</b>	<b>12</b>	<b>254.2</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1 Албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн талаар

#### 1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч зурж, тайлан баланс гаргаж байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын Засаг дарга	1								1	